



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.08.06 № 1840
таний -ны № -т

**ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМЫН
ДАРГА Ц. ГАНХУЯГ ТАНАА**

Г Хандивын тайлангийн дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойргуудад явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцох “Иргэний зориг ногоон нам”-ын ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэгт заасны дагуу хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Нам нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6, 26.4.6-д заасны дагуу иргэн хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэгт заасны дагуу Төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар баталсан төрийн бус байгууллагын санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Төрийн аудитын дээд байгууллага нь хандивын тайланг Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон бусад холбогдох хуулийн дагуу хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын дээд байгууллага хүлээхгүй болно.

Дүгнэлт

“Иргэний зориг ногоон нам” 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэж тайлagnaагүй байна.

Хувийг: Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хороонд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

Z:\Yawsan\Bichiq\2021\0806 ADG-18.Docx

10000004



01031153